



ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 56

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.6, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012 оны 13-07-016/116 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 10,528,895 /арван сая таван зуун хорин найман мянга найман зуун ерэн тав/ төгрөгийн балансын үнэтэй, 9,651,039 /есөн сая зургаан зуун тавин нэгэн мянга гучин ес/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Эрүүл мэндийн төвийн барилга, 6,400,487 /зургаан сая дөрвөн зуун мянга дөрвөн зуун наян долоо/ төгрөгийн балансын үнэтэй, 6,019,506 /зургаан сая арван есөн мянга таван зуун зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Эрүүл мэндийн төвийн гал тогооны барилгыг тус тус акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Э.Одончимэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

430219135

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 03 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР